

Хотын стандарт хяналтын газар

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн мэдээ гаргах заалт  
/ 2023 оны YII сарын тайлан мэдээ /

2023 оны 08 дугаар сарын 08

Улаанбаатар хот

Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	2023 оны YII сарын хэрэгжилтийн <b>үр дүнгийн тухай</b> мэдээлэл	Хэрэгжилтийн үнэлгээ					30 болон 0 үнэлгээтэй бол удаширсан шалтгаан		Хэрэгжилтийн явц		
			100	70	30	0	ХБ	Санхүүжилтээс	Зохион байгуулалтас	Үргүүлэх хэрэгжих	Бүрэн хэрэгжсэн	Тодорхой ахцى гарсан
	3Г-ын тогтоол											
Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай 2023-01-11 Дугаар 2023_79	3. Хяналт шалгалтын үйл ажиллагаанд шаардагдах зардлыг 2023 оны батлагдсан төсөвтөө багтаан, шаардлагатай бол зохицуулалт хийн санхүүжүүлж, цаашид холбогдох эх үүсвэрийг жил бүрийн улсын төсвийн төсөлд батлуулж байхыг Засгийн газрын холбогдох гишүүд, Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Байгууллагын чиг үүргийн дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаанд шаардлагатай бичиг, тээвэр шатахууны зардлыг 2023 оны батлагдсан төсөвт зохицуулалт хийх замаар санхүүжүүлэн ажиллаж байна.		+							+	
	3Г-ын хуралдааны тэмдэглэл											
2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл 2022-05-11	XX.5.1. Хот, суурин газрын ногоон байгууламж, явган зам, дугуйн замын норм, нормативын баримт бичиг, стандартыг мөрдүүлэх, хэрэгжүүлэх, олон улсын жишигт нийцүүлэх, боловсронгуй болгох талаар шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг	Нийслэлийн хэмжээнд 2023 онд улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй явган болон дугуйн замын шинэчлэлтийн дараах ажлуудад стандарт, нормыг мөрдүүлэх чиглэлээр хяналт тавин ажиллаж байна. Үүнд: - Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас 20 байршлын 20000 м2 явган зам,		+							+	

Дугаар 2022_28	<p>Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга наарт тус тус даалгав;</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Нийслэлийн Замын хөгжлийн газрын 30000 м2 явган зам,</li> <li>- Хан-Уул дүүргийн 1, 2, 3, 15 дугаар хороо Дунд голын гудамж, 11, 19, 20, 22, 23, 24 дүгээр хорооны нийт 7565 м2 явган зам,</li> <li>- Баянзүрх дүүргийн 25, 26, 36 дугаар хороо 12,619 м2 явган зам,</li> <li>- Чингэлтэй дүүргийн 16 байршилд 8000 м2 явган зам,</li> <li>- Баянгол дүүргийн 8 байршилд 1600 м2 явган зам, Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй Хорооллын эцсээс Өргөө Кино театрын уулзвар хүртэлх 730м дугуйн замын ажил.</li> </ul> <p>Мөн Эрчим хүчний яамны захиалгаар "Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл"-ийн хүрээнд Бага тойрууд дулааны магистраль шугамыг өргөтгэн, шинэчлэх ажлын явцад Эрчим хүчний яам, Улаанбаатар Дулааны сүлжээ ТӨХК, Улаанбаатарын ус сувгийн удирдах газрын холбогдох инженер техникийн ажилчидтай хамтран газар дээр нь хяналт тавьж ажилласан. Уг дулааны шугамын угсралтын ажил дууссаны дараагаар хийгдэх явган замын тохижилтын ажилд UCS 0901B "Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавих ерөнхий шаардлага"-ыг хангаж ажиллах талаа зөвлөмж өгч ажилласан.</p>							
	<p>ХХ.5.2. Хот, суурин газрын ногоон байгууламж, явган зам, дугуйн замын норм, нормативын баримт бичиг, стандартаар тогтоосон шаардлагыг хангуулах асуудлыг хуульчлах боломжтой эсэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумьяабазар болон хувийн хэвшлийн төлөөлөл бүхий хамтарсан ажлын хэсэг байгуулан судалж, танилцуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатарт даалгав.</p>	<p>Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулинд нийслэл хот стандарттай байх бөгөөд түүнийг Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлаас баталж нийтээр дагаж мөрдөхөөр зохицуулсан. Энэхүү зохицуулалтын хүрээнд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар нийслэлийн хэмжээнд мөрдүүлэх 9 бүлгийн 38 хотын стандартыг баталж 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдүүлж эхэлсэн. Дээрх 9 бүлгийн 38 хотын стандартад ногоон байгууламжтай холбоотой -5, явган зам, дугуйн замтай холбоотой-2 хотын стандарт тус тус батлагдсан.</p> <p>Батлагдсан хотын стандартыг мөрдүүлэх арга хэмжээг үе шаттай зохион байгуулж Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/851 дүгээр захирамж, 2023 оны А/242 дүгээр захирамжаар</p>	+ +						

		стандарт, нормын мөрдүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулах хэрэгжилтийг хангулан ажиллаж байна. 2023 оны хувьд нийт 126 арга хэмжээ бүхий нэгдсэн төлөвлөгөөнд тохижилт, бүтээн байгуулалтын ажилд ногоон байгууламж, явган зам, дугуйн замын стандарт, норм, дүрмийг мөрдүүлэх хүрээнд зөвлөн туслах, хяналт тавих чиглэлийн нийт 18 арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Иймд ногоон байгууламж, явган ба дугуйн замын стандарт, нормыг мөрдүүлэх асуудлыг хуульчлах асуудал бүрэн хэрэгжсэн гэж үзэж болно.							
2022 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр 47 дугаар тэмдэглэл 2022-09-28 Дугаар 2022_47	IX.14. Нийслэл Улаанбаатар хотод оршин суух, явганаар болон дугуйгаар зорчих эрүүл, аюулгүй орчин, боломжийг бүрдүүлэх, хайс, хашааг буулгаж явган замын тасралтгүй байдлыг хангах, сүлжээг одоогийн байгаагаас хоёр дахин нэмэгдүүлэхийг Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт;	Нийслэлийн иргэдийн амьдрах орчныг сайжруулж, эрсдэлийг бууруулах чиглэлээр дараах арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд: 1. Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/242 дугаар захирамжийн дагуу иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлын 11 үзүүлэлтээр хийгдсэн судалгаагаар нийслэлийн төвийн 6 дүүргийн хэмжээнд явган замын стандартын шаардлага хангаагүй, эрсдэлтэй нийт 1240 байршлыг тогтоосон. Уг судалгааны дэлгэрэнгүйг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 01/877 тоот албан бичгээр хүргүүлсэн. 2. Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/394 дүгээр захирамжийн дагуу Баянгол, Баянзүрх, Сүхбаатар дүүргийн нийт 46 байршилд хашаа, хайсыг стандартын шаардлагад нийцүүлэхээр ажиллаж байна. Эдгээр байршлуудад газар дээр нь ажиллаж, холбогдох иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад UCS1410B:2022 “Хашаа, хайс, хашлагад тавих ерөнхий шаардлага” хотын стандартын дагуу шинэчлэх талаар зөвлөмж хүргүүлсэн.		+					+

---оо---

Хотын стандарт хяналтын газар

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн мэдээ гаргах заалт  
/ 2023 оны YIII сарын тайлан мэдээ /

2023 оны 09 дүгээр сарын 05

Улаанбаатар хот

Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	2023 оны YIII сарын хэрэгжилтийн үр дүнгийн тухай мэдээлэл	Хэрэгжилтийн үнэлгээ					30 болон 0 үнэлгээтэй бол удааширсан шалтгаан	Хэрэгжилтийн явц	
			100	70	30	0	ХБ			
	3Г-ын тогтоол									
Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай 2023-01-11 Дугаар 2023_79	3. Хяналт шалгалтын үйл ажиллагаанд шаардагдах зардлыг 2023 оны батлагдсан төсөвтөө багтаан, шаардлагатай бол зохицуулалт хийн санхүүжүүлж, цаашид холбогдох эх үүсвэрийг жил бүрийн улсын төсвийн төсөлд батлуулж байхыг Засгийн газрын холбогдох гишүүд, Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Байгууллагын чиг үүргийн дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаанд шаардлагатай бичиг хэрэг, тээвэр шатахууны зардлыг 2023 оны батлагдсан төсөвт багтаан зохицуулалт хийх замаар санхүүжүүлэн ажиллаж байна.	+							

	ЗГ-ЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ										
2022 оны 5 дугаар сарын 11-ийн өдөр 28 дугаар тэмдэглэл 2022-05-11 Дугаар 2022_28	ХХ.5.1. Хот, суурин газрын ногоон байгууламж, явган зам, дугуйн замын норм, нормативын баримт бичиг, стандартыг мөрдүүлэх, хэрэгжүүлэх, олон улсын жишигт нийцүүлэх, боловсронгуй болгох талаар шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав;	Стандарт, нормыг мөрдүүлэх чиглэлээр дараах ажлыг зохион байгуулан хяналт тавин ажиллаж байна. Үүнд: - Авто зам, замын байгууламжийн ажлын даалгаварт UCS0901B:2022 “Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавих ерөнхий шаардлага” хотын стандартыг тусгах талаар Нийслэлийн Замын хөгжлийн газарт албан бичиг хүргүүлэв. - Баянзүрх дүүргийн 26-р хороо Дүнжингаравын баруун урд уулзвараас Их Монгол улсын гудамж хүртэл шинээр хийгдэж буй явган зам болон дугуйн зам ажилд UCS 0901B:2022 “Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавих ерөнхий шаардлага”, UCS 0903B:2022 “Унадаг дугуйн замын төлөвлөлт, хучилтад тавих ерөнхий шаардлага” хотын стандартын шаардлагад нийцүүлэх талаар гүйцэтгэгч аж ахуйн нэгжид газар дээр зөвлөмж өгч ажиллав.		+						+	

	XX.5.2. Хот, суурин газрын ногоон байгууламж, явган зам, дугуйн замын норм, нормативын баримт бичиг, стандартараар тогтоосон шаардлагыг хангуулах асуудлыг хуульчлах боломжтой эсэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар болон хувийн хэвшилийн төлөөлөл бүхий хамтарсан ажлын хэсэг байгуулан судалж, танилцуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатарт даалгав.	Барилгын салбарын төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг сайжруулах зорилтын хүрээнд холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, НЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэст хүргүүлэхээр ажиллаж байна. Тус саналд Хот байгуулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.6.3 дахь заалтад “Төлөвлөгөөнд хамааруулсан нийт газар нутгийн 60-аас доошгүй хувь нь стандартад нийцсэн ногоон байгууламж, цэцэрлэг, замын байгууламж байна” гэж өөрчлөлт оруулахаар тусгав.		+										+
2022 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр 47 дугаар тэмдэглэл 2022-09-28 Дугаар 2022_47	IX.1.14. Нийслэл Улаанбаатар хотод оршин суух, явганаар болон дугуйгаар зорчих эрүүл, аюулгүй орчин, боломжийг бүрдүүлэх, хайс, хашааг буулгаж явган замын тасралтгүй байдлыг хангах, сүлжээг одоогийн байгаагаас хоёр дахин нэмэгдүүлэхийг Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт;	Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Хууль, журмын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/394 дүгээр захирамжийн хүрээнд Баянгол дүүргийн 38, Баянзүрх дүүргийн 4, Сүхбаатар дүүргийн 4, нийт 46 байршилд UCS1410B:2022 “Хашаа, хайс, хашлагад тавих ерөнхий шаардлага” хотын стандартыг мөрдүүлэх чиглэлээр хяналт тавин ажиллаж байна. Дээрх байршилд хамаарах хашаа, хайсыг эзэмшигч, ашиглагч байгууллагуудад зөвлөмж, мэдэгдэл хүргүүлж нийт 29 байршилд стандартын шаардлагыг хангуулсан.		+										+

---оОо---